

**ДЭЭД БОЛОВСРОЛД ХАМААРАХ ЭРДМИЙН ЗЭРГИЙГ ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨХ
ТУХАЙ ДЭЛХИЙ ДАХИНЫ КОНВЕНЦЫГ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН
ТӨСЛИЙГ ХЭЛЭЛЦСЭН ТАЛААРХ АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН
БАЙНГЫН ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ**

2024 оны 04 дүгээр
сарын 23-ны өдөр

Улаанбаатар
хот

Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяа

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 04 дүгээр сарын 18-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Дээд боловсролд хамаарах эрдмийн зэргийг хүлээн зөвшөөрөх тухай дэлхий дахины конвенцыг соёрхон батлах тухай хуулийн төслийг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо 2024 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд Дээд боловсролд хамаарах эрдмийн зэргийг хүлээн зөвшөөрөх тухай дэлхий дахины конвенцод нэгдэн орсон улсууд харилцан бие биенийхээ боловсролын үнэлгээг хэрхэн хүлээн зөвшөөрөх, харилцан ямар туслалцаа дэмжлэг үзүүлэх, энэ талаарх тодорхой туршлага, бодит жишээ байгаа эсэхийг асууж, хариулт авсан.

Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан тухайн конвенцод нэгдэн орсноор дэлхийн улс орнуудын дээд боловсролд хамаарах эрдмийн зэрэг, хэсэгчилсэн сургалтыг харилцан хүлээн зөвшөөрч байгаагаас гадна дүрвэгсэд ба шилжин суурьшсан этгээдийн хамрагдсан хэсэгчилсэн сургалт ба эрдмийн зэргийг хүлээн зөвшөөрөхөөр заасан нь дүрвэгсдийг хүлээн авахыг зөвшөөрдөггүй манай улсад нөлөө үзүүлэх эсэх талаар анхаарах шаардлагатайг онцлон тэмдэглэсэн болно.

Дээд боловсролд хамаарах эрдмийн зэргийг хүлээн зөвшөөрөх тухай дэлхий дахины конвенцыг соёрхон батлах тухай хуулийн төслийг чуулганы нэгдсэн хуралдаанд оруулж эцэслэн батлуулахыг дэмжье гэсэн саналыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Дээд боловсролд хамаарах эрдмийн зэргийг хүлээн зөвшөөрөх тухай дэлхий дахины конвенцыг соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцсэн талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД
БОДЛОГЫН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА**



Б.ЭНХ-АМГАЛАН

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**КОНВЕНЦ СОЁРХОН
БАТЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллагын 2019 оны Ерөнхий бага хурлын 40 дүгээр чуулганаар баталсан “Дээд боловсролд хамаарах эрдмийн зэргийг хүлээн зөвшөөрөх тухай дэлхий дахины конвенц”-ыг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон баталсугай.

Гарын үсэг